БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БАГА АНГИАС ДУНД АНГИД ШИЛЖИХ ҮЕИЙН ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ГЭР БҮЛИЙН ХҮРЭЭНД ДЭМЖИХ ЗӨВЛӨМЖ

УЛААНБААТАР

2023

Өмнөх үг

Бид хүүхдүүдээ бага ангиа төгсөөд дунд ангид ороход ямар дэмжлэг үзүүлэх вэ?, Дасан зохицох чадварыг хэрхэн дэмжих вэ?, Шилжилтийг хэрхэн амжилттай даван туулахад нь туслах вэ?, Хүүхдүүдтэйгээ хэрхэн хамтран ажиллах вэ? Эдгээр асуултад хариулт өгөх зорилгоор энэхүү гарын авлагыг бэлтгэлээ.

Энэ гарын авлагад хүүхдийн хөгжлийн өргөн агуулгыг багтаахаас илүүтэй хүүхэд анги дэвших, бага ангиас дунд ангид шилжин суралцахад нэн тэргүүнд анхаарч хөгжүүлбэл зохих дасан зохицох чадварын талаар санаа өгүүлэх болно.

Зохиогчид

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 5-Р АНГИАС 6-Р АНГИД ШИЛЖИХ ҮЕД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР ЯАГААД ЧУХАЛ ВЭ?



Хүүхдүүд цэцэрлэгээс нэгдүгээр ангид элсэн суралцах үед дасан зохицох үеийн эхний үе шат явагддаг. (Н.И.Шевандрин, 1995) Харин бага ангиас дунд ангид шилжин суралцах үед өсвөр насны шилжилтийн үе давхцаж дасан зохицох чадварын хоёрдахь үетэй тулгарах шаардлагатай болдог. Эцэг эх, асран хамгаалагчид бид хүүхдийн дасан зохицох чадварын хоёрдахь үе шатын талаар ойлголт хаанаас олж авах вэ? Дасан зохицох чадвар гэж юу вэ?

Дасан зохицох чадвар гэдэг нь : Хүрээлэн буй орчинд илүү сайн амьдрах боломжийг бүрдүүлэх бие махбодийн ба зан үйлийн шинж чанар юм.

Дасан зохицох чадварт: - Шинэ зүйл туршиж, янз бүрийн нөхцөлд асуудлыг шийдэх байдлаар суралцах боломжтой.

Хүүхэд бүрийн дасан зохицох чадвар харилцан адилгүй байдаг эцэг эх, асран хамгаалагчид бид аль болох богино хугацаанд сургуулийн орчинд дасгах, суралцах чадварыг дэмжихдээ сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, ангийн багш, бусад мэргэжлийн багш нартай хамтран ажиллах боломж бий.

Ийм учраас эцэг эх, асран хамгаалагчид бид гэр бүлийн харилцааны хүрээнд хүүхдийнхээ ДАСАН ЗОХИЦОХ чадварыг дэмжин ажиллах нь үүрэг хариуцлага болоод байна.

Дунд ангид орход ХҮҮХДҮҮДИЙН өмнө - олон багш олон төрлийн хичээл орж даалгаврын тоо нэмэгдэж, багш, тэнгийнхэнтэйгээ харилцах (өөр хүүхдүүдтэй нэг анги болох, шинэ найз нөхөд бий болох зэрэг нь зарим талаар бэрхшээлтэй санагдана) харилцаанд өөрчлөлт орох, дүрэм хэм хэмжээ өөрчлөгдөх гэх мэт дасан зохицохыг шаардсан асуудлууд бий болдог. Мөн өсвөр насны шилжилтийн үе нь биологи-физиологи-сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийг бий болгодог ба хөгжлийн чухал үе юм.

Суралцагч бага ангиас дунд ангид амжилттай шилжин суралцаж байгаа нь дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Сэтгэлийн түгшүүргүй, амгалан тайван
- Өөрийн зан төлөвийг хянан зохицуулдаг

- Өөртөө итгэлтэй
- Сурах дур сонирхолтой
- Бусдыг хүлээн зөвшөөрдөг, бусадтай эерэг харилцаатай
- Сургуулийн сайн дурын үйл ажиллагаа, клуб, секцэд хамрагддаг

Дээрх эерэг хандлагууд нь цаашид дэвшин суралцах, сэтгэл зүйн эерэг хандлагыг бий болгоход чухал нөлөөтэй.

Энэ нь хүүхдэд хэд хэдэн өөрчлөлтүүдийг бий болно. Үүнд:



- Шинэ дүрэм журам, хэм хэмжээ
- Орчин хэрэглэгдэхүүний өөрчлөлт
- Олон цагаар хичээл орж, хичээлийн тоо, агуулга нэмэгдэх
- Хичээл бүр өөр өөр шаардлага тавигдах,
- Бие дааж суралцахуйд нь гарах өөрчлөлт
- Үе тэнгийхэн, ангийнхан, гэр бүлийнхний харицлааны өөрчлөлт гарах гэх мэт



Эдгээр эерэг өөрчлөлт нь сурагч ангин дэвшин амжилттай суралцах, нийгэм сэтгэл зүйн эерэг хандлагыг бий болгоход чухал үүрэгтэй.

Сурагчид бага ангиас дунд ангид шилжих үе нь бие бялдар, оюун ухаан, сэтгэл хөдлөл, ёс суртахууны хувьд өөрчлөгддөг үе юм. Зарим хүүхдүүд бусдаасаа хурдан дасан зохицдог. Зарим хүүхдийн хувьд дасан зохицох чадвар сул байдаг нь сурлагын хоцрогдол, цаашилбал, сургууль завсардалтад хүргэх эрсдэлтэй учир энэ үед эцэг эх, асран хамгаалагчид багштай хамтран шилжилтийг амжилттай давах, суралцах чадварыг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй. Жишээлбэл: хүүхэд дунд ангид ороод сурлагаар хоцрох, сурах сонирхолгүй болох, өөртөө итгэх итгэлгүй болох, зан төлөв харилцааны зөрчилд орох гэх мэт олон сөрөг байдлууд илэрч болно.

6-р ангид ороод таны хүүхдийн бие даан хийж эхлэх зүйлс:

- Хичээлдээ бие даан ирж, буцах,
- Хичээлийн хуваарийн дагуу дэвтэр, номоо бэлтгэх, гэрийн даалгаврыг цаг тухай бүрд нь хийх,
- Бие даан суралцах чадвараа сайжруулах
- Өдөр тутам хийх ажлаа цагийн хуваарийн дагуу хийж сурах зэрэг болно.



Шилжилт гэж юу вэ?

Бид хүүхдээ боловсролын түвшин бүрийн сургалтад хамруулдаг. Жишээ нь: 2-5 нас хүртэл СӨБ буюу ясли, цэцэрлэгт хамруулдаг ба 6 насанд нь ЕБС-ийн бага ангид элсэн суралцуулдаг. Өнөөдөр бидний хүүхдүүд бага боловсролын түвшинд 5-р ангид суралцаж байгаа ба удахгүй дунд боловсролын түвшинд 6-р ангид дэвшин суралцах буюу хамгийн чухал үедээ ирж байна.

Бага ангиас дунд ангид шилжин суралцах нь хүүхдийн боловсролын түвшинд шилжих үеүдээс хамгийн чухал шилжилтийн нэг юм.

Шилжилтийн энэ үед сэтгэц-физиологийн хувьд гарах өөрчлөлт нь хүүхдэд сэтгэл санааны хямралыг үүсгэж болно.

Нэгэн багшийн ярианаас

Манай сургууль бага анги төгссөн сурагчдаа эцэг эх, асран хамгаалагчдын хамт хүлээн авах нээлттэй өдөрлөг зохион багш нараа заадаг хичээл нэг бүрээр мэргэжлийн зэрэг болон ур чадварын талаар мэдээлэл өгч танилцүүлдаг уламжлалтай.

Бид хүүхдийнхээ дасан зохицох чадварыг дэмжих боломжтой юу?

Хүүхдийнхээ хөгжил сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд эцэг эхчүүдийн анхаарал маш чухал.

Хүүхдийнхээ дасан зохицох чадварыг дэмжихдээ сургууль-багштай хамтын ажиллагааг бий болгох энэ нь эцэг эх, асран хамгаалагчид өөрсдөө сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дуу хоолойгоо сонсох, хоёрдугаарт, багш хүүхэд хоорондын харилцаа хандлагыг сайжруулах хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Зөвлөмж

- Дунд ангид хүүхэд элсэн суралцсанаар сургалтын орчин хэрхэн өөрчлөгдөх ба энэ нь хүүхдэд ямар нөлөө үзүүлэх талаар ангийн багштай хамтран таниулаарай.
- Хүүхдээ хэрхэн хөгжүүлэх хэрэгцээ, хүсэл эрмэлзлэлийнх нь талаар багш нараас “зөвлөгөө авч байнга харилцаатай байгаарай
- Анги сургуулийн үйл ажиллагаанд оролцох нь хүүхдийн хөгжилд чухал холбогдолтойг ойлгож сургууль багш нартай хамтарч ажилладаг байгаарай.
- Сургуулийн хүрээний үйл ажиллагааны талаар багшаас мэдээлэл авч хамтран ажиллаарай
- Хүүхдийнхээ сурах үйлийг дэмжих чадварыг дэмжихэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг хамруулаарай.
- Та хүүхдийнхээ хичээлд суух боломжийг бүү алдаарай.

БАГА АНГИАС ДУНД АНГИД ШИЛЖИН СУРАЛЦАХ ҮЕД ХҮҮХДЭД ГАРАХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Хүүхдийн хөгжлийг бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлогоор тодорхойлдог.



Бага ангиас дунд ангид шилжих шилжилтийн үе нь хүүхдийн шилжилтийн настай давхацдаг ба энэ үед биологи-физиологи сэтгэл хөдлөлийн өөрчлөлттэй хүүхдүүд тулгардаг.

Бие бялдрын хөгжил нь булчингийн болон хөдөлгөөний хөгжлийг илэрхийлнэ. Хүүхдийн бие бялдрын хөгжилд гарч буй өөрчлөлт нь тархи, мэдрэлийн үйл ажиллагааны илрэл тул танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжилтэй салшгүй холбоотой юм. Нийгэмшил нь нийгмийн орчинд амьдарч суралцах, өөрийгөө мэдрэх, харилцааны явцад илэрхийлэх, гэр бүлийнхэн, найз нөхөд болон бусадтай харилцах чадварыг илэрхийлнэ. Танин мэдэхүйн хөгжил нь бие даан сурах чадвартай холбоотой, хэл ярианы хөгжилтэй уялдуулан суралцах чадварыг илэрхийлнэ.



Хүүхдийн бие бялдрын хөгжлийн нас тус бүрийн дундаж үзүүлэлт хүйсээр[1]

	Биеийн өндөр (см)		*Биеийн жин (кг)*		*Бүсэлхийн тойрог (см)*		*Гарын атгах хүч (кг)*	
Хүйс	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид
10 нас	138.52	137.83	33.54	32.99	60.04	58.24	11.43	10.36
11 нас	142.63	146.55	36.29	39.15	60.68	61.71	15.60	14.33

Бие бялдрын хөгжил: Хүүхэд 10 насандаа өөрийн биеийн үйлдэл хөдөлгөөнөө хянах зохицуулах чадвар сайжирна. Булчингийн хүч нэмэгддэг. Биеийн том булчингийн хөгжил эрчимтэй хөгждөгтэй холбоотой үсрэх, харайх, гүйх, биеийн тэнцвэрээ орох, дасгал хөдөлгөөн хийх, бүжиглэх чадвартай болдог бол 11 насанд хүүхдийн биеийн өндөр, жин нэмэгддэг. Мөн шилжилтийн настай холбоотой бие махбод, физиологийн хөгжлийн эрчимтэй үе юм.



Сэтгэцийн хөгжлийн эрүүл саруул байдал нь бие бялдрын өсөлт хөгжлийн үзүүлэлттэй салшгүй холбоотой ба хоол, тэжээлийн хангалт, биеийн дасгал хөдөлгөөн нь хүний амьдралын туршид чухалд тооцогддог.

Таны хүүхдэд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх дараах асуултуудад Та хариулаад үзээрэй.

		Тийм	Үгүй
1	Биеийн өндөр, жин нэмэгдэж байна уу?		
2	Биеийн том булчингийн хөгжил явагдаж байна уу?		
3	Хөдөлгөөний эвсэлтэй байна уу?		
4	Өглөөний цайгаа байнга уудаг уу?		
5	Спортын ямар нэг төрлийг сонирхож хичээллэхийг хүсэж байна уу?		
6	Таны хүүхэд өөрийнхөө бие бялдрын үзүүлэлтүүдэд шүүмжлэлттэй хандах юм уу эсвэл санаа тавьж байна уу?		

Хэрвээ “тийм” гэсэн ихэвчлэн хариултуудыг сонгосон бол таны хүүхдийн хөгжил хэвийн явагдаж байна гэж үзэж болох ба хэрвээ өөрийн биеийн хэлбэртээ сэтгэл хангалуун бус, хөдөлгөөний эвсэлгүй байна гэж үзэж байвал Та биеийн тамирын багштай нь хамтран дасгал хөдөлгөөн хийлгэж дэмжих боломжтой.

Та хүүхдийнхээ бие бялдрын хөгжилд ямар өөрчлөлтүүд орж болохыг мэдээрэй

Бие бялдар	Өөрчлөлтүүд
Биеийн өндөр	Өсвөр нас (11-14 нас) нь биеийн өндөр, жин нь хурдан буюу 2 дахин нэмэгдэж бие махбодод нь өөрчлөлт ордог үе юм.
Биеийн жин	Хүүхдүүд энэ үед өөрийнхөө бие бялдрын хөгжилд санаа тавьж эхэлдэг байна.

[1] Монгол хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлог УБ 2023

Бэлгийн бойжилт	Хүүхдэд гарах өөрчлөлтийн нэг нь бэлгийн бойжилт бөгөөд охидод 9-11 насанд, хөвгүүдэд ихэвчлэн 13 насанд эхэлдэг. Охид ихэвчлэн бэлгийн бойжилтын эхэн үед хурдан өсдөг. Дараа нь эхний сарын тэмдгийн үед (сарын тэмдэг) өсөлт удааширдаг онцлогтой байна.
	Өсвөр насандаа хөвгүүд охидоос намхан байдаг ч өсөлт эхэлсний дараа хөвгүүд илүү хурдан, охидоос илүү өсгөлүүн болдог.
Анхаарах, дэмжих зүйлс	Багийн спортоор хичээллүүлэн хөдөлгөөнийг сайжруулах. Хөвгүүдийн хувьд – булчингийн масс нэмэгдэж байгаа тул хүчний болон тэсвэр тэвчээрийг хөгжүүлэхийг оролдож болно. Өсөлт идэвхтэй хурдтай ядагддаг учир хөдөлгөөн нь болхи байж болно.
	Хүүхдийг сургуулиас зохион байгуулж буй спортын тэмцээн уралдаан, өдөрлөгт тогтмол оролцохыг нь дэмжих, Спортын ямар нэгэн секц дугуйланд хүүхдээ явуулах, энэ нь тэдний биеийн өсөлт хөгжилтөд эерэгээр нөлөөлөхөөс гадна хүүхэд өөрийн үйлдэл хөдөлгөөнөө зохицуулах чадвар, нөхөрсөг, хамтач, тэвчээртэй, сахилга баттай зан гэх мэт эерэг нийгэмшлийг бий болгоход туслах болно.
	Хүүхдийн биеийн тамирын хичээлд оролцох оролцоог нь хангах, түүнд ач холбогдол өгөх, биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг гэртээ хийх боломж бүрдүүлэхэд анхаарах. Эцэг эх нь ялангуяа, аав нь хүүхэдтэйгээ хамтдаа биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх, хамтран тоглох, дасгал хөдөлгөөний чадвар, дадалтай болоход нь туслан дэмжих нь бие бялдрын хөгжлийг дэмжих чухал хүчин зүйл юм.
	Сургуулийн бага насанд хүүхэд том булчингийн хөгжил, авхаалж самбаа, хөдөлгөөний эвсэлд эерэг нөлөө үзүүлэхүйц спортын төрөл болох бассейн, цана, тэшүүр гэх мэт спортоор хичээллүүлэх нь илүү үр дүнтэй.
	Хүүхдийн уян хатан чанарыг хөгжүүлэхэд бүжиг, гимнастикийн дугуйлан секц үр дүнтэй. Хүүхдийн гар, нурууны хүчийг тусгайлан хөгжүүлэх шаардлагагүй боловч хүүхдийн биеийн жингийн 10 хувиас хэтрэхгүй ачааг хүүхдээр өргүүлж байх нь тэдний булчингийн хөгжилд эерэгээр нөлөөлнө. Жишээ нь, 2-3 л сүү өргөх, шат өөд цүнхээ урдаа үүрч дороос нь дэмжих, гулгуурын бариулаас барьж өөдөө өгсөж гарах, хөндлөвчнөөс дүүжигнэж тоглох гэх мэтээр хүүхдийн хүчний чанарын хөгжлийг дэмжиж болно.
Унтах цаг	Хүүхдийг тогтсон цагт унтуулж сургах, аль болох 21-22 цагийн хооронд унтуулж хэвшүүлэх нь бие бялдрын хөгжлийг дэмжих болно.

Бие бялдрын чадварыг дэмжих үйлийг тусгахдаа:



10-11 насанд хүүхдүүдийн биеийн ерөнхий хөгжил тухайлбал толгойн тойрог, биеийн жин, бүсэлхийн тойрог, цээжний тойрог, биеийн өндөр нас нэмэгдэх нь насны зүйн тогтол, физиологийн хөгжлийн дагуу явагдаж байгааг илэрхийлнэ.

- Хүүхдүүд удаан хугацаагаар нурууны булчинг чангалан суух нь анхаарлаа төвлөрүүлэх чадварт сөргөөр нөлөөлнө.

- Гарын жижиг булчинг дэмжсэн даалгаврыг ачааллыг нь хэтрүүлэхгүйгээр гүйцэтгүүлээрэй.
- Хөдөлгөөний уян хатан эвслийг хөгжүүлэхэд үр дүнтэй арга зүйн элементийг тусгах нь үр дүнтэй юм.

Өсөж том болохын нэг чухал хэсэг бол бусадтай харьцаж, **нийгэмшиж сурах явдал** юм. Таны хүүхэд:



- Ганцаараа байхаас илүү олон найз нөхөд, бусад хүмүүстэй харилцах болно.
- Найз нөхөрлөл илүү чухал болно.
- Гэхдээ таны хүүхэд таныг эцэг эхийн хувьд хайрлаж, гэр бүлийн гишүүн байх дуртай хэвээр байна.

Таны хүүхдэд эдгээр насанд илэрч болох нийтлэг шинж чанаруудыг доор харуулав

Нийгэмшил	Дунд ангид шилжин суралцах нь хүүхдийн боловсролын түвшинд шилжих үеүдээс хамгийн чухал шилжилтүүдийн нэг юм.
Дасан зохицох	Дасан зохицох чадвар сайтай залуучууд хичээлдээ оролцох, дуртай байх, сургуульдаа сэтгэл хангалуун байх, өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр, амьдралын утга учир, зорилгыг илүү тодорхой мэдэрдэг. Дасан зохицох чадвар нь тэсвэртэй чадвараас илүү үр дүнг урьдчилан таамаглаж эхэлдэг.
Ээнэгшилт	Хүүхдүүд нь эцэг эхээсээ илүү үе тэнгийнхэндээ ханддаг, Хүүхдүүд нь хүлээн зөвшөөрөгдөж, итгэлцлийг эрэлхийлдэг, Хүүхдүүд нь насанд хүрэгчдийн бэлэн шийдлээс татгалзаж, өөрсдийнхөө талд хандах хандлагатай байдаг. Хүүхдүүд нь эрх мэдэл, гэр бүлийн үнэ цэнд эргэлздэг
	Тэд өөрсдийгөө үргэлж гол дүр гэж үздэг Өөрсдийгөө бусадтай харьцуулдаг Хувийн нууцыг эрэлхийлдэг Шилжилтүүд нь сорилтуудыг авч ирдэг ба энэ нь сэтгэл хөдлөлийн хувьд суралцах боломж олгоно
Дүрэм журам	Сургалтын шинэ орчинд шилжих нь дэг журам дагаж мөрдөх шаардлага үүсгэнэ Нийгмийн амьдрал, найз нөхөд, таалагдах зэрэгт санаа зовдог Тэд шударга ёс, тэгш байдлыг чухал асуудал гэж үздэг
Дэмжлэг, анхаарах зүйл	Хүүхдүүдэд өөрийнхөө мэдрэмж сэтгэл хөдлөлөө таньж ойлгоход нь туслах, ямар үед бусдаас дэмлэг туслалцаа авах вэ гэдгийг нь ойлгуулах, асуудлыг шийдвэрлэх ерөнхий чадварт сургаж байгаа нь дунд сургуульд шилжин суралцах үеийн томоохон дэмжлэг болно.
	10-11 настай хүүхдүүдийн бага ангиас дунд анги руу шилжих нь өсвөр үеийнхний үе тэнгийнхнээ хүлээн зөвшөөрөхөд нөлөөлж, эцэг эх, асран хамгаалагч багш нарын удирдамж чиглүүлэлт чухал байдаг байна. 10-12 насны хүүхдэд үзүүлэх гэр бүлийн дэмжлэгээс илүүтэй үе тэнгийнхний дэмжлэг чухал.

	Найз нөхөддөө итгэх итгэлийг ойлгож дэмжих нь хүүхдүүдийн түрэмгий зан авирыг бууруулж, нөхөрлөлийн талаар илүү сайн ойлголттой байх нь өсвөр үеийнхнийг шилжилтийн тулгарах бэрхшээлүүдээс хамгаалах боломж үүсгэнэ.



“Би хийх ёстой зүйлээ хэнээр ч хэлүүлэлтгүй хийдэг” болох нь хүүхдүүд бие даасан, өөртөө шүүмжлэлтэй хандах, өөрийн үнэлгээ хөгжиж байгаатай холбоотой. Хүүхдүүд бие даах тусам эцэг эхээсээ хамааралтай байдал буурдаг нь нас зүйн онцлог юм.

Таны хүүхдэд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх дараах асуултуудад Та хариулаад үзээрэй.

		Тийм	Үгүй
1	Хийх ёстой зүйлээ хэнээр ч хэлүүлэлтгүй хийж байна уу?		
2	Бие даасан болж байна уу?		
3	Өөртөө болон бусад зүйлд шүүмжлэлтэй хандаж байна уу?		
4	Өөрийгөө үнэлэх үнэлгээ хөгжиж байна уу?		
5	Бусад хүмүүсийг сонсож чадаж байна уу?		
6	Найзуудтайгаа адилхан харьцаж байна уу?		
7	Яриаг нь сонсход дуртай байна уу?		
8	Хүмүүсийн хэлсэн зүйлийг зөв буруу гэж ялгаж байна уу?		
9	Хэн нэгэнтэй муудалцаж байна уу?		

Хэрвээ Та ихэвчлэн “**үгүй”** гэсэн хариултыг сонгосон бол - Орчиндоо сөрөг хандлагатай, сөрөг сэтгэлийн хөдөлгөөнөө шууд илэрхийлдэг, бусдыг хүлээн зөвшөөрөхгүй байх хандлагатай. Буруугаа хүлээн зөвшөөрдөггүй.

Дундаж Бусдын бодол санаа, үйл ажиллагааг өөрт нь таалагдсан үед хүлээн зөвшөөрдөг, шүүмжлэлтэй хандах чадвартай.

Хэрвээ Та ихэвчлэн “**тийм”** гэсэн хариултыг сонгосон бол - Орчиндоо үргэлж эерэг ханддаг, заримдаа бусдад таатай байх үүднээс аялдан дагалдах хандлагатай, шинэ орчинд амархан дасдаг гэх мэт онцлогтой байна. Та энэ талаар **ангийн багш болон сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй** хамтран тэднээс зөвлөгөө авч ажиллах боломжтой.



Нийгэмшлийн чадварыг дэмжих үйлийг тусгахдаа:

- Хүүхдийнхээ идэвхтэй зан чанарыг дэмжээрэй.
- Хүүхдийнхээ бусадтай нийцтэй байх чадварыг нь урамшууллын аргаар дэмжээрэй.
- Хүүхдийнхээ бусдын шахалт шаардлагаар аливаа үйлийг гүйцэтгэж буй байдлыг ажиглаж, өөрийн санал санаачилгыг нь урамшуулан дэмжээрэй.
- Хүүхдийнхээ өөртөө хандах хандлага, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэхийн тулд хүүхдийн чадварт тохирсон даалгавар гүйцэтгүүлэхийг хичээгээрэй.

- Хүүхдийнхээ хариуцлагатай, идэвхтэй, өөрийгөө хүлээн зөвшөөрөх, бие даах чадварыг нь хөгжүүлэхэд гэрийн даалгаврыг заавал гүйцэтгүүлэн, харилцан хэлэлцэх аргыг хэрэглээрэй.
- Хүүхдэд өөрийн болон найз нөхдийнхөө сэтгэлийн хөдөлгөөнийг таньж, ойлгож харилцах чадварыг нь дэмжээрэй.
- Сэтгэл санаагаа нээлттэй илэрхийлэх чадварыг нь дэмжээрэй.
- Хүүхдээ бусадтай бүү харьцуулаарай. Энэ нь хүүхдэд түгшүүр үүсгэдэг шүү.
- Шинэ хичээлүүдийг шинэ багш нар хичээл зааж байгаатай холбоотой хүүхдэд түгшүүр үүсэж болохыг тооцоорой. Эцэг эх, асран хамгаалагчид бид хүүхдүүдтэйгээ ялангуяа энэ насанд харилцахдаа элэгсэг нээлттэй, тэвчээртэй, сэтгэлийн хөдөлгөөний сөрөг илрэлээс зайлсхийгээрэй.

10-11 нас нь танин мэдэхүйн хөгжлийн маш чухал үе юм. Тэдний танин мэдэхүй нь илүү хийсвэр шинжтэй болдог. Сэтгэхүйн үйлдлүүд эрчимтэй хөгжих бөгөөд тэд юмсыг дотоод учир шалтгаан, зүй тогтолд нь танин мэдэх чадвар сайжирдаг байна.

Миний хүүхэд энэ насанд юу хийж чадах вэ?

Танин мэдэхүй	
Хүртэж хүлээж авах	Юмсын энгийн шинж болох өнгө, хэлбэр дүрс зэргээр нь ангилах чадвар сайтай.
Анхаарал	Анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллахдаа бэрхшээдэг тул тухайн чадварыг нь дэмжих хэрэгцээтэй байна.
Ой тогтоолт	Энгийн богино үлгэр, өгүүллэгийг утгаар нь тогтоох нь амархан учир бодит утга бүхий танил үгийн хүрээнд энгийн өгүүлбэрээр бичих боломжтой болно. Утгын ой тогтоолт сайтай хүүхдүүдийн богино хугацаанд энгийн дүрс, тэмдэглэгээг харж тогтоох, үгэн мэдээллийг сонсож тогтоох нь сайн байдаг байна.
	Богино хугацаанд дүрс мэдээллийг харж тогтоох, өгүүллэг үлгэрийг ойлгож тогтоох, математик үйлдэл хийх чадвартай болсон.
Сэтгэхүй	Энгийн зүйлс, үг хэллэг зэргийг адил төстэй шинжээр нь бүлэглэх боломжтой болно;
	бодит сэтгэхүй давамгайлдаг ч юмсыг шинж, бүтцээр нь задлан шинжлэх, ижил төсөөтэйгээр нь ангилах нэгтгэх сэтгэхүйн үйлдэл нь танин мэдэхүйн хөгжилд чухал үүрэгтэй байна.
Хэл яриа	Бодит ахуйн шинжтэй үгийн нөөцтэй. Хийсвэр үг, салаа/ижил утгтай үг, тэмдэг нэрийн утгыг хүүхэд ойлгох, үгийн нөөцтэй Энгийн богино өгүүлбэрээр юмсыг харагдаж байгаагаар нь тоочин ярьдаг, 10 наснаас нийлмэл өгүүлбэрийн хэрэглээ сайжирдаг байна. 2 минутад зорилго чиглэлтэйгээр санаа бодлоо илэрхийлэхдээ дунджаар 34-35 үгийг хэргэлдэг байна.

Зөвлөмж	Гэрийн даалгавар хийхэд хүүхэд дур сонирхолтой хэцүү санагдахгүй байх тал дээр багштай хамтрах, Хүүхэд багшаасаа дэмжлэг, мэдээллийг чөлөөтэй авах, нээлттэй харилцаатай байхад туслах Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээдээ дэмжлэг үзүүлэн гэрийн даалгавраа бие даан хийдэг болгох нь тэдний танин мэдэхүйн чадварыг сайжруулах боломжтой байна. Хүүхдүүд гэртээ компьютер, интернэттэй байх нь танин мэдэхүйн хөгжилд нь эерэгээр нөлөөлдөг учир боломжтой зүйлсээр хангах.
	Хүүхдүүдээ бид боловсролын түвшин бүрд хамруулах нь тухайлбал СӨБ-д, бага боловсролд хамруулах нь хүүхдүүдийн танин мэдэхүйн чадварыг хөгжүүлдэг. Ялангуяа, анхаарлаа төвлөрүүлэх, мэдээллийг тогтоох, үгийн нөөц, сэтгэхүйн чадварт нь эерэгээр нөлөөлдөг байна.
	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцдог, спортоор хичээллэдэг хүүхдүүдийн юмсыг хүлээж авах ойлгох, тогтоох, хэл яриа, сэтгэхүйн чадвар сайн байна. Хүүхдүүдийн унтаж амрах цаг хангалттай байх буюу 22-23 цагт унтуулах нь танин мэдэхүйн чадварт нь эерэгээр нөлөөлдөг.

Таны хүүхдэд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх дараах асуултуудад Та хариулаад үзээрэй.

	Асуултууд	Тийм	Үгүй
1	Юмсыг ажиглаж тогтоох дуртай байна уу?		
2	Анхааралтай сууж даалгавраа хийж байна уу?		
3	Анхаарал хурдан сарнидаг уу, удаан хугацаанд анхаарлаа төвлөрүүлэн ажиллахад ядарч байна уу?		
4	Таны асуусан асуултад хүүхэд тань бүтэн өгүүлбэрээр хариулж байна уу?		
5	Юмс/мэдээллийг ерөнхийд нь хурдан ойлгодог уу?		
6	Юмыг харж тогтоох нь сайн уу?		
7	Юмыг сонссон зүйлээ сайн тогтоодог уу?		
8	Аливаа үзэгдэл юмс үйл явдлыг гадаад өнгөц шинжээр хүлээж авч, дүгнэдэг үү?		

Хэрвээ Та ихэнх асуултуудад “**тийм”** гэсэн хариулт сонгосон бол хүүхдийн хөгжил хэвийн явагдаж байна. Харин зарим нэг асуултуудад үгүй гэдэг хариулт сонгосон бол ангийн багштай хамтран хүүхдээ дэмжээрэй мөн нэмэлт сургалтад хамруулж болно.



Танин мэдэхүйн чадварыг дэмжихдээ:

➢Бид хүүдийнхээ анхаарлын тогтворжилтыг нэмэгдүүлэхийн тулд гэртээ баримтлах **дэгтэй** байх нь чухал ба дэгийг ТА хүүхдүүдтэйгээ хамтран боловсруулаарай.

➢Хүүхдээ даалгавар хийх нөхцөлийг бүрдүүлж хамтран даалгавар хийхэд нь туслаарай. Даалгаврыг нэг дор удаан хугацаагаар хийлгэх нь тэднийг залхааж, ядраадаг тул зайлсхийж, бүрэн гүйцэт хийлгэснээр танин мэдэхүйг нь бид дэмжиж өгөх боломжтой болно.

- Гэртээ эцэг эх, асран хамгаалачтайгаа хамтран хурд шаардсан, өрсөлдөөнтэй тоглоом тоглох нь хүүхдийн сэтгэхүйн хурдыг хөгжүүлдэг.
- Хүүхдийнхээ мэдээллийг утгачлан тогтоох чадварыг хөгжүүлэхийн тулд агуулгыг сайн ойлгуулаад давтуулах, тайлбарлах, дүрслэх, ойлгосноо зургаар илэрхийлүүлэн зуруулах нь үр дүнтэй. Үүнийг хүүхдүүдтэйгээ хамтран хийгээрэй.
- Хүүхдийнхээ хэл яриа сэтгэхүй, үгийн санг нэмэгдүүлэхийн тулд танил бус үг болох салаа утгатай үг, нэр үгийг тайлбарлан утгыг нь ойлгуулж өгөөрэй.

БИЕ ДААН СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ХЭРХЭН ДЭМЖИХ ВЭ?

Эцэг эх, асран хамгаалагчид ангийн багш, багш нартай хамтран ажиллах нь амжилтад хүрхэд чухал. Эцэг эх, асран хамгаалагчдид бид хүүхэдтэйгээ хамтран суралцах төлөвлөгөө, дэг зохиож, өөрийнхөө хүүхдэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Бие даан суралцах гэдэг нь өмнө нь мэддэггүй, чаддаггүй байсан ямар нэг зүйлийг эзэмшихийг хэлдэг. Хүүхэд шинэ зүйлтэй тулгарсанаар суралцаж эхэлдэг. Эцэг эх, асран хамгаалагчид бид хүүхдийнхээ орчин нөхцөлийг бүрдүүлсэнээр суралцах идэвхийг нэмэгдүүлэх боломжтой. Хүүхэд юу мэддэг, чаддаг болсон бэ гэдгээс илүү тухайн хүүхдийн зан үйлд ямар эерэг өөрчлөлт гарсан бэ гэдгээр авч үзэх нь чухал бөгөөд энэ нь хүүхдийн ямар шинэ зүйл сурсан байна вэ гэдгийг “тодорхойлно”.

Хүүхэд хэрхэн суралцдаг вэ?



Хүүхэд өөрийн оролдлого, ажиглалт, даган дуурайж хийж байгаа үйлээрээ суралцаж байдаг. Хүүхдүүд эцэг эх, насанд хүрэгчдийг, гэр бүлийн гишүүдээ харж, багш нараа ажиглаж, тэдний бодит үлгэр дуурайллаас суралцдаг. Хүүхдүүд үг яриа, үйл хөдлөлийг даган дуурайхаас гадна хандлагыг ч хүртэл дуурайдаг. Үүгээр хүүхдийн сурах үйл ажиллагаа ихэвчлэн явагддаг бөгөөд тэд өөрийг нь хайрладаг, ойр дотны хүмүүсээсээ "үлгэр дууриалал" авдаг. “ХҮҮХЭД АЖИГЛАХ ЯВЦ” -ад тэдний тархинд суралцах процесс явагдах буюу урьд өмнө мэддэггүй байсан шинэ зан үйлийг мэдэж авна, ашиглана, эзэмшсэн зан үйлээ өөрөөр илэрхийлэх боломж олгоно.

Тоглох явцдаа суралцдаг

Хүүхдийн хувьд тоглох, суралцах нь хамтдаа нэг үйл. Тоглох үйл хүүхдийн өөрийн санаачилгаар бий болох бөгөөд тэд тоглоомоороо юу хүсэж байгаа, юу чаддагаа харуулна. Хүүхэд тоглох явцдаа суралцахад эцэг эх, насанд хүрэгчдийн өдөөлт, санаа чухал. Хүүхэд тоглоомоороо тойрон хүрээлж буй орчинтойгоо танилцаж, өдөр тутмын хэрэглээний эд зүйлс, юмсыг юунд хэрэглэдэг, юугаараа ялгаатай зэргээр ойлголт төсөөлөлтэй болно, хөдөлгөөний чадвар, эв дүй нь сайжирна, бусадтай харилцах, асуудлыг шийдвэрлэх арга ухаанд суралцана. Тэд тоглохдоо ихэвчлэн анхаарлаа төвлөрүүлж, хийж буй үйлээ үнэнчээр гүйцэтгэсээр байдаг.

Та хүүхдээ суралцахад нь хэрхэн дэмжих вэ?

Та бүхэн хүүхдийнхээ сурах үйлийг дэмжсэн, олон боломж олгосон буюу айх зүйлгүй туршиж үзэх, тааламжтай орчинг хамгийн түрүүнд бүрдүүлж өгөөрэй. Тэндээс л Таны хүүхэд сурах үйлээ хэрхэн гүйцэтгэх арга замаа олж авна.

Та хүүхдийнхээ:

- Хүүхдийнхээ сурах үйлд анхаарлаа хандуулж, тусалж дэмжихэд бэлэн байх

- Хүүхдийнхээ чадварт итгэж, өөрөө бие даан олон зүйлийг туршиж үзэх боломж олгох
- Оролдож туршиж үзэх, сурхыг нь дэмжих, санаа авах орчныг бүрдүүлэх
- Үг хэллэг, үйл хөдлөл бүрдээ хянамгай хандаж, үлгэр дуурайл үзүүлэх
- Хүүхэдтэйгээ хамт тоглох
- Хүүхдээ алдаа гаргах, урам хугарсан үед нь найрсаг, хайраа илэрхийлэн хандах
- Суралцах үйл нь үргэлж хөгжилтэй, баяр баясгалантай байхад анхаарах

Энэ насны хүүхдийн сэтгэхүйн онцлогийг бодит сэтгэхүйгээс хийсвэр сэтгэхүйд шилжих үе гэж тодорхойлж болно. Хийсвэрлэх сэтгэлгээ хөгжиж, математик, логик, ёс суртахууны асуудлыг задлах, нэгтгэх чадвартай болж эхэлнэ. Юмыг сониучирхах, эргэцүүлэн бодох дуртай байдаг.

Бидний анхаарах зайлшгүй дэмжих сул зан чанарууд нь

- өөрийгөө удирдах чадвар муутай
- зориг тэвчээр багатай
- тогтворгүй
- хувьсамтгай болдог.
- нийгмийн бичил орчинд орж олон янзын хүмүүстэй харилцана. Иймд энэ үед нь бусдыг хүндэтгэн үздэг, өрөвч зөөлөн харилцаанд сургахыг хичээгээрэй.

ГЭРИЙН ДААЛГАВАР ХЭРХЭН ХИЙЛГЭХ ВЭ? ЗӨВЛӨМЖҮҮД

Эцэг эх, асран хамгаалагч бид хүүхдүүд гэрийн даалгавраа сайн, зөв хийж байж л хүүхэд маань сайн суралцана гэсэн боддог. Гэтэл бодит амьдралд гэрийн даалгавар, ялангуяа 5-р ангиа төгсөж дунд ангид суралцах гэж байгаа хүүхдүүдэд гэрийн даалгавар төгсөлтийн шалгалт хамгийн их ачаалал үүсгэж, бэрхшээл учруулдаг, ядраадаг, залхаадаг зүйл. Үүний үр дагаврыг зайлшгүй ойлгох нь чухал.

Баримт судалгаа

“ Хийж байгаа зүйлийг нь бүү тасал. Хэрэв хүүхэд тань туслалцаа хүсвэл харин дэмжлэг үзүүлэхэд бэлэн бай. Тэдэнд нэг талаас сэтгэл санааны дэмжлэг, нөгөө талаас тодорхой аргачлал л хэрэгтэй”. Роберт-Кох-Гимназын захирал Хайнц-Петер Майдингер (Heinz-Peter Meidinger)

“Гэрийн даалгаврыг хүүхэд ямагт төгс төгөлдөр хийх албагүй. Харин ч түүний эсрэгээр. Хэрэв гэрийн даалгавар хийхдээ хүүхэд алдсан, тэр нь харагдаж байвал тухайн хүүхдэд ямар дэмжлэг хэрэгтэй байгаа талаар багшид чухал мэдээлэл өгнө” гэж тэмдэглэсэн байна.

Эцэг эх, асран хамгаалагчид бид хүүхдэдээ гэрийн даалгавар болон суралцахад нь хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ? Эцэг эх, асран хамгаалагчид анхнаас нь хүүхдээ дэмжиж туслах шаардлагатай юу? Жишээлбэл, гэрийн даалгавар хийхэд нь гэх мэт.

Гэрийн даалгавар хийхэд :

- Хүүхэд тус бүрд өөрөө шийдэж суралцах боломжийг бүрдүүлэх
- Гэрийн даалгаврыг хүүхэд бүгдийг зөв гүйцэтгэх албагүй.
- Гэрийн даалгавар бол сайн дүн авахын төлөө хийж буй ажил биш бөгөөд харин дутуу ойлгосон зүйлээ шинээр сурсан зүйлээ бататгаж буй үйлдэл

- Зарим эцэг эх хүүхдийнхээ гэрийн даалгаварт илүү анхаарч, нэмэлт сургалтад хамруулдан ойлгоогүй зүйл дээр нь давтлага авч хүүхдийнхээ сурлагын амжилтыг ахиулдаг
- Эцэг эх, асран хамгаалагчид бид хүүхдүүдээ хоорондоо адилгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх
- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээрээ даалгавар олон дахин давтан хийлгэснээр түүнд авъяас чадвар бий болгоно гэж үгүй.
- Хүүхээ тохирсон номын сантай болгож ном унших боломжтой болгох.

Баримт судалгаа

Мэргэжлийн хяналтын газраас IV-V ангийн сурагч өдөрт 2 цаг даалгавар хийх зөвлөмж гаргасан байдаг. ЕБ -ийн 15 сургуулиас " Хичээлийн цаг, агуулга, гэрийн даалгавар" гэсэн гурван бүлэгт судалгаа явуулсан. Зөвхөн гэрийн даалгавар гэсэн бүлгийг авч үзэхэд судалгаанд оролцсон сурагчдын 45 хувь нь гэрийн даалгавар их өгдөг учир хичээлд явах ямар ч сонирхол байдаггүй, 11 хувь нь гэрийн даалгавар хийгээгүй үедээ албаар хичээлээ тасалдаг гэж хариулсан байна.

Гэрийн даалгаврын зорилго нь – хичээл дээр үзсэн сэдвийг давтах, батагах, түүнчлэн мэдлэгээ хэрэглэх практик дадлыг төлөвшүүлэх явдал байдаг. Үүнд:

- *Үзсэн хичээлийг бататгадаг*. Хүүхэд даалгавар хийгээгүйгээс хичээл дээр үзсэн мэдээллийн 50-70 хувийг мартдаг. Хэрвээ хүүхэд даалгавар хийж хичээлээ давтахгүй бол сэдэв болгоныг үзэж судлах цаг нэмэгдэж хоцрох нь нэмэгдэнэ.
- *Сурлагын амжилтад эерэгээр нөлөөлдөг*. Гэрийн даалгавар хийхэд өдөр бүр 30-90 минут зарцуулдаг хүүхдүүд математикийн шалгалт дээр хийдэггүй хүүхдүүдээс өндөр үнэлгээ авсан байдаг. Хүүхдүүдийн ачаалал нэмэгдэх тусам сурлагын амжилтын дундаж үнэлгээ нэмэгддэг зүй тогтолтой байна.
- *Мэдлэгийг хянадаг*. Гэрийн даалгавар хэр хийсэнээр багш нар тухайн хүүхэд хичээлийн агуулгыг эзэмшсэн түвшинг үнэлж дүгнэх боломж олгодог.
- *Өөрийн зохион байгуулалттай*: Гэрийн даалгавар бие даан бие даан хийх нь ажиллах зуршил бий болгож насанд хүрсэн үед нь зайлшгүй хэрэг болгодог өөрийн зохион байгуулалтад сургадаг. Хүүхдүүд юмсын дэс дарааг олох, өөрийнхөө цагийг хуваарилах, мэдээлээ хайх, шүүмжлэх сэтгэлгээ, олон зүйлээс гол чухалыг ялгаж олох дадал туршлага олж авдаг. Ийм дадал суусан хүүхдүүд ирээдүйд амжилт олох илүү их боломж олж авдаг.

Нэгэн ээжийн яриа

Манай хүүхэд зургаадугаар ангид сурдаг. Хичээлийн бус цагаар математикийн хичээлээр сонгон суралцаж байгаа. Хичээл тараад 2 цаг давтлагдаа суугаад орой гэртээ ирдэг. Ирэнгүүтээ л гэрийн даалгавраа хийх хэрэгтэй болдог. Багаар бодоход 2-3 цаг зарцуулж байна. ээжийнх нь хувьд ядаргаанд орчих вий гэж санаа зовох юм.

Гэрийн даалгаврын давуу тал

 ХАРИЛЦАА, ХАНДЛАГА

Өөрийн харилцаа, хандлага

- Дунд ангид биеэ дааж суралцахын тулд ямар ямар өөрчлөлтүүд гарах талаар ойлголт баримжаатай болгох

- Бага багаар өөртөө зорилт тавьж бие дааж, өөрийнхөөрөө шийддэг чадварыг нь дэмжих
- Хүүхдийнхээ өөртөө итгэлтэй зан төлөвийг нь дэмжих
- Өөрийгөө бодитоор үнэлэх чадварыг нь дэмжих
- Хүүхдийнхээ сайн талд тулгуурлан сул талыг нь засах талд хамтран ажиллах
- Хүүхдийнхээ ахмад болон бусад хүмүүстэй хүндэтгэлтэй, ажил хэрэгч харилцдаг болгох, ингэснээр хүүхэд өөрийн тухай зөв ойлголт хандлагатай болох талыг дэмжих

Хүмүүс хоорондын харилцаа

- Хүүхдээ хэрхэн хүмүүстэй харилцаах талаар ойлголт өгөх
- Үе тэнгийн хүүхдүүд хоорондоо хэрхэн харилцах, онцлогийн талаар ойлголт өгөх
- Харилцааны явцад ямар нэг бэрхшээл үүсэх үед хэнд хандах талаар ойлголт баримжаа өгөх
- Хувийн онцлогийг таньж харилцах талаар хүүхэдтэйгээ хамтран ярилцах
- Найз нөхдийнх нь дунд хүүхдийнхээ нэр хүндийг эрхэмлэх.
- Хүүхэдтэйгээ ямагт дотно, тэгш харилцаатай байх.

Сургалтын орчин, мэдээлэлтэй харилцах

- Дунд ангийн хичээллэх орчин, соёл, үйлчилгээ, дүрэм журам, хэм хэмжээ онцлогтой танилцуулах нь дасан зохицолтын үр дүнтэй
- Хүүхэддээ дунд ангид ороод олон хичээл орох тухай хичээлийн хөтөлбөрийн онцлог/судлагдахууны төрөл, гүнзгийрэлт, түүний ач холбогдлыг тайлбарлан ойлгуулах нь үр дүнтэй.

Жишээ 1:

Нэгэн ээжийн ярианаас:

Хүүхдээ 6-р ангид ороход нь бие даасан том болсон гэж үзээд даалгаврыг нь давтуулах, хажууд нь сууж зөвлөж хийхээ больчихсон байсан. Хүүхдээ юм асуухаар одоо өөрөө хий багш чинь заасан биз дээ гээд эхний үед тэгж хэлдэг байсан. Ямар нэг зүйл асуухаар нь одоо мэдэхгүй юм байна аа номоо сайн унш л гэж хэлдэг байлаа. Тэгсэн манай хүүхэд надтай ярьдаг, хичээлээ асуудаг нь нэг мэдсэн байхгүй болчихсон байсан.

Энэ тохиолдолд өгөх зөвлөгөө:

- Та хүүхдүүдийнхээ анхаарал, сонирхлыг татах ямар нэгэн арга заавал хэрэглээрэй.
- Хүүхдүүдээс асуулт асууж, хариултыг нь урамшуулаарай.
- Хүүхдээ яагаад заавал сурах, ёстой бие дааж сурах нь ямар хэрэгтэйг хүүхдээ ойлгуулаарай.
- Хүүхдийн алдааг хэлэх шаардлагатай бол зөвхөн гаргасан алдааг нь хэлж дараа нь сайн талыг нь хэлээрэй.

Жишээ 2:

6-р ангийн сурагчийн ярианаас

Би уул нь 5-р ангид байхдаа хувийн сургуулиас энэ ангидаа шилжин ирж суралцсан юм. Тэгээд ангидаа сайн дасаагүй байж байгаад 6-р ангид орсон. Бас сайн дасаагүй анги, шинэ олон багштай, сайн дотно найзгүй байсан. Олон хичээл даалгавар гээд ойлгоогүй зүйлээ багшаасаа

илүү аав ээжээс асуухаас гадна эгчээсээ асуудаг байсан. Тэд нар бас сайн мэдэхгүй, туслах боломжгүй болохоор нь асуухаа больсон.

Энэ тохиолдолд өгөх зөвлөгөө:

- Хэрэв та хүүхдээ шилжүүлэн сургах гэж байгаа бол эхлээд сургуулийн орчин нөхцөлтэй танилцуулаарай,
- Ангийнхаа хүүхдүүдтэй танилцах, найзлах хамтран хичээллэх суралцахад нь туслаарай
- Даалгавар хийхэд нь хамтран туслаарай.
- Хүүхэдтэйгээ нээлттэй харилцаарай.
- Найз нөхөдтэй болж байна уу байнга ярилцаж байгаарай.

Зөвлөмж

- Сургуулийн орчинтой танилцуулах, сургуулийн үйлчилгээнүүдийг хэрхэн авах, ямар хүмүүст хандах талаар сайн танилцуулаарай.
- Ямар багш нар ямар хичээл заах талаар нэг бүрчлэн хүүхэддээ танилцуулаарай.
- Хүүхэдтэйгээ Та харилцахдаа ямагт нүүр рүү нь харж яриарай, ярьж байхдаа буруу харах, өөр юм хийх, дээрээс харилцах зэрэг нь хүүхдийн өөртөө итгэх итгэлийг бууруулж, айдсыг нэмэгдүүлнэ.
- Хүүхэдтэйгээ Та ямагт хүндэтгэлтэй харилцсанаар хүүхэд бусдад үнэ цэнтэй хүн гэдгээ мэдэрдгийг анхаарч ажиллаарай. Энэ нь хүүхэд эрхээ хамгаалах чадварт суралцахад чухал
- Хүүхэдээ хүндлэх мэндлэх зан үйлийг хэвшүүлээрэй. Та өөрөө хүүхэдтэйгээ эсвэл бусад хүмүүстэй эхэлэ мэндэлдэг байгаарай. Энэ нь хүмүүстэй нээлттэй харилцах чадвар, хүндлэх мэндлэх ёсонд сургах хамгийн үр дүнтэй арга.
- Хүүхэддээ Та баярлалаа гэж дотноор хэлж байгаарай.
- Хүүхдүүдийн хувийн онцлогийг ажиглаж таньдаг байгаарай. Хувийн онцлогт нь хүндтэглэтэй хандаж эв дүйтэй харилцаарай.
- Хүүхдийн дасан зохицох чадварт нийцүүлэн ганцаараа ажиллах, даалгавар өгөхдөө өөрийг нь ялгаварласан мэт мэдрэмж төрүүлэхгүйн тулд эв дүйтэй хандахыг хичээгээрэй.
- Дасан зохицох чадвар өндөртэй хүүхдэд бусдаас давуу гэсэн мэдрэмжийг өөрт нь болон бусдад төрүүлэхгүй байхад анхааараарай.
- Та хүүхдэдээ гэрийн ажилтай холбоотой даалгавар өгсөн бол заавал түүнийг нь үнэлээрэй. Энэ нь хүүхдэд хариуцлагатай зан төлөвийг төлөвшүүлдэг.
- Та асуулт асуух, заавар өгөхдөө ойлгоогүй байж магадгүй санагдвал давтан хэлэхээсээ бүү цааргалаарай.
- Хүүхдүүдтэйгээ хүний ёс суртахуун төлөвшил, үнэт зүйлийн талаар хэлэлцдэг байгаарай.
- Хүүхэдтэйгээ харилцахдаа Та дуу хоолойныхоо өнгийг зөв зохицуулахад байнга анхааралтай хандаарай.
- Хүүхдийнхээ эерэг зан төлөвийг урамшуулан дэмжиж байгаагаа илэрхийлдэг байгаарай.

Жишээ 1.

Эерэг харилцаатай эцэг эх, асран хамгаалагчийн шинж

- Хүүхдээ анхааралтай сонсдог

- Хүүхдийнхээ асуулт, хариулт, даалгавар хийхэд хамтран тусалдаг.
- Хүүхдээ бодитоор урамшуулдаг, магтдаг.
- Хүүхдээ шүүмжилдэггүй, сайн талыг нь олж магтдаг.
- Асуулт асуугаад асуултад хариулт авахдаа бүтэн өгүүлбэрээр хариулт авдаг.
- Хүүхэдтэйгээ ойр зайнаас харилцдаг.
- Гэр бүлтэйгээ хамтран тоголдог, хийх зүйлийг нь дэмждэг.
- Хүүхэддээ заавар тодорхой өгдөг.
- Хүүхдийн шинэ санал санаачилгыг дэмждэг, туршиж үзэх боломж олгодог.

Энэ тохиолдолд өгөх зөвлөгөө:

- Хүүхдийн ярьж байгаа, асууж байгаа зүйлийг эхнээс нь дуустал нь сонсож байгаарай. Хүүхэдтэйгээ ярилцах цаг гаргадаг байгаарай.
- Хүүхэд ойлгосон эсэхийг ажиглан таньдаг байгаарай. Ойлгоогүй гэж үзвэл эхнээс нь тайлбарлах, эсвэл асуулт асуух, асуултад нь хариулдаг харилцааны стратеги баримтлаарай.
- Дуу хоолойны өнгө нь хэт хурдан, эсвэл хэт удаан, хэт чанга, эсвэл хэт сул биш байхад анхааараарай.
- Хүүхэдтэй харилцахдаа нуруугаа үүрэх, хамраа, чихээ оролдох, алгаа хооронд нь үрэх, гараа урдаа зөрүүлэх, халаасандаа гараа хийх, хуруугаараа заах, доошоо харах, эсвэл хэт дээрээс харах, алгаа доош нь харуулж ярих зэргээс зайлсхийгээрэй. Хэрэв алгаа харуулах үйлдэл хийвэл алгаа дээш нь харуулж яриарай. Энэ нь илэн далангүй байдлын илэрхийлэл. Мөн хүүхэдтэй бага зэрэг бөхийж харилцах нь анхааралтай хандаж байгаагийн илэрхийлэл байдгийг санаарай.

Эцэг эх, асран хамгаалагчдын бид хүүхдээ дасан зохицох чадварыг дэмжихдээ, гэр бүлийн хүрээнд харилцахдаа, анхаарах зүйлс:

- Хэрвээ хүүхдээ урамшуулдаг бол өөртөө итгэх итгэлтэй болдог.
- Хэрвээ хүүхэд үргэлж ичиж зовохыг мэдэрдэг бол өөрийгөө буруутгадаг.
- Хэрвээ хүүхдийг хүлээцтэй хүмүүжүүлсэн бол тэвчээртэй болдог.
- Хэрвээ хүүхдийг хүлээцтэй хүмүүжүүлсэн бол тэвчээртэй болдог.
- Товчоор бол бид ямар байна хүүхдүүд маань тийм байхыг л сурна.

Та бид гэр бүлийн хүрээнд хүүхэдтэйгээ харилцахдаа ямар нэг алдаа гаргахгүй байхыг хичээгээрэй.

Хүүхдэдээ үргэлж зөв үлгэр дуурайл үзүүлээрэй. Өөрийнхөө сурган хүмүүжүүлэх мэдлэг, арга барилаа цаг үргэлж баяжуулж сайжруулж байгаарай. Хүүхдэд эерэг нөлөө үзүүлэх аргыг хэрэглэхийг хичээгээрэй. Хүүхдээ үргэлж ажиглан судалж байгаарай. Хүүхэдтэйгээ хамтран тоглох, ажил хөдөлмөр хийж байхыг гэр бүлийнхээ амьдралын дадал зуршил болгох зэрэг арга барилыг хэрэглээрэй.

Хүүхдүүд эцэг эх бусад хүмүүсийн аливаа зүйлийг яаж хийж, санаа бодлоо хэрхэн илэрхийлэх, бусдадяаж хандаж байгааг ажиглаж байдаг. Дараа нь түүнээсээ суралцдаг. Иймд хүүхдийнхээ дэргэд муухай үг хэллэг хэлэхгүй, буруу үйлдэл хийхгүй хайр энхрийллээ мэдрүүлж байвал зөв үлгэр дуурайлал болно.

Эцэг эхчүүдийн гаргадаг нийтлэг алдаа

-
- Хүүхдээ сонсдоггүй.
- Ажлаа хүүхдээсээ илүүд үздэг.
- Хүүхэдтэйгээ нээлттэй байдаггүй.

- Хүүхдэд анхаарал тавьдаггүй
- Хүүхдээ буруу дутуу ойлгодог.
- Хүүхдийг ойлгохгүй өөрийнхөөрөө байлгах гэдэг
- Хүүхдээ хэтэрхий дураар нь байлгах.

Эцэг эх, асран хамгаалагчдад өгөх зөвлөмж

- Хүүхдээ хайрлаж байгаагаа илэрхийлж байх
- Авьяас чадварыг нь хөгжүүлэх
- Санал бодлыг нь сонсож байх.
- Өөрөө өөрөөр нь шийдвэр гаргуулж алдаа оноог нь засаж залруулах.
- Та хүүхэдтэйгээ тодорхой зүйлүүд дээр үеийн юм шиг найз нь болж харьцаж бай.
- Хүүхэдтэйгээ харилцан ярилцдаг байгаарай.
- Хүүхдээ найз нөхөдтэй нь бүү харьцуул.
- Хүүхдэд худал бүү хэл.